



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын гуравдугаар хавсралтын 3, 14 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2026/05-11/ШТА-НА) тайлан, акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2027 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор хариу ирүүлэхийг дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нарт зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2027 оны 1 дүгээр улиралд танилцуулахыг Гүйцэтгэл, нийцлийн аудит хариуцсан ахлах менежер (Ч.Болд)-д үүрэг болгосугай.

4. Тайланг дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.



Г.НАНДИНЖАРГАЛ

1426010018



АГУУЛГА

Гарчиг	Хуудас
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн жагсаалт	4
Хавсралтын жагсаалт	4
Дүрслэлийн жагсаалт	4
Зургийн жагсаалт	4
Ерөнхий зүйл	5
Ерөнхий мэдээлэл	6
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх	7-12
БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх	13-16
БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй эсэх	17-22
БҮЛЭГ 4. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг хууль журмын дагуу олгож, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх	23-25
Аудитын дүгнэлт	26
Аудитын зөвлөмж	27
Холбогдох байгууллагын санал	28-29
Саналд өгсөн тайлбар	30-32
Хавсралтууд	33-61



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ГУББГ	Геоземи усны барилга байгууламжийн газар
ДЗД	Дүүргийн засаг дарга
ДИТХ	Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ДТХО	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НД	Налайх дүүрэг
НЗХГ	Нийслэлийн замын хөгжлийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СБД	Сүхбаатар дүүрэг
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СС	Сангийн сайд
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТГ	Тамгын газар
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УБ	Улаанбаатар
УБЗЗАГ	Улаанбаатар зам засвар арчлалтын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хувьцаат хариуцлагатай компани
ЧД	Чингэлтэй дүүрэг



Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлт	6
Хүснэгт 2	Дүүргүүдийн 2025 оны батлагдсан төсвийн өөрчлөлтүүд	7
Хүснэгт 3	Хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлсэн байдал	9
Хүснэгт 4	Төсөв баталсан тогтоолын өөрчлөлт	11
Хүснэгт 5	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга	13
Хүснэгт 6	ХАА-г 2025 оны 05 дугаар сарын 31-ээс хойш зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт	13
Хүснэгт 7	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт	17
Хүснэгт 8	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд	21
Хүснэгт 9	ДТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-нд олгосон санхүүжилт	23
Хүснэгт 10	2025 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги	23
Хүснэгт 11	Хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал	24

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг
Хавсралт 1	Төсвийн зарчмыг мөрдлөг болгоогүй ТАХ-ний жагсаалт
Хавсралт 2	Төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт хавсаргаагүй ТАХ-ний жагсаалт
Хавсралт 3	Саналгүй тусгагдсан ТАХ-ний жагсаалт
Хавсралт 4	Дүүргүүдийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүй ТАХ-ний жагсаалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцээгүй ТАХ-ний жагсаалт
Хавсралт 5	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-ний жагсаалт
Хавсралт 6	Ерөнхий нэршлээр тусган баталсан ТАХ-ний жагсаалт
Хавсралт 7	Ажлын даалгаваргүй, төсөв батлагдсаны дараа баталгаажсан ТАХ-ний жагсаалт, Зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлтгүй батлагдаж, төсөв батлагдсаны дараа баталгаажсан ТАХ-ний жагсаалт, Техникийн тодорхойлолтгүй, төсөв батлагдсаны дараа баталгаажсан ТАХ-ний жагсаалт
Хавсралт 8	Дүүргүүдийн төсөв баталсан тогтоолоор өөрчлөлтөөр төсөвт өртөг, санхүүжих дүн, өссөн ТАХ-ний жагсаалт, Дүүргүүдийн төсөв баталсан тогтоолоор өөрчлөлтөөр төсөвт өртөг, санхүүжих дүн, буурсан ТАХ-ний жагсаалт

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	Шинээр хэрэгжих ТАХ-ний ангилал	6
Дүрслэл 2	Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний ангилал	8
Дүрслэл 3	ТАХ-г хэрэгжүүлэх шатанд, багцад задарсан байдал	10
Дүрслэл 4	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсан ТАХ	10

Зургийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Зураг 1	Төсөвлөлийн шаардлага хангаагүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй ТАХ	18
Зураг 2	Захиалагчийн хяналт бүрэн хэрэгжүүлээгүй, чанартай гүйцэтгэгдээгүй ТАХ	19
Зураг 3	Чанартай гүйцэтгээгүй ТАХ	20
Зураг 4	Аудитын явцад бүрэн гүйцэтгүүлсэн ажлууд	22
Зураг 5	Ашиглалтгүй байгаа тоног төхөөрөмжүүд	25



ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 7 дугаар зүйлийн 7.1, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/174 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилт

Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнтэй эсэх;
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг хууль журмын дагуу олгож, хөрөнгийн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад дүүргүүдийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн ИТХ, ЗДТГ, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгж болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, гэрээний хэрэгжилт, санхүүжилт зэргийг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Барилгын тухай хууль;
- ✓ Авто замын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- ✓ Дүүргүүдийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт;
- ✓ Батлагдсан төсөвт зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дүүргүүдийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 212,425.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 434 ТАХ, шилжин хэрэгжих 407,158.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 358 ТАХ, нийт 619,583.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 792 ТАХ-г хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 1. Дүүргүүдийн 2025 оны төсөв батлах тухай тогтоолын өөрчлөлт

(сая.төг)

№	Дүүргийн нэр	ДИТХ-ын 2025 оны сүүлийн тодотгол								
		Он дамжин хэрэгжих			Шинэ			Нийт ТАХ		
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	БГД	32	29,408.7	19,098.8	32	27,629.6	26,629.6	64	57,038.3	45,728.4
2	БЗД	51	81,989.2	36,610.8	27	14,602.7	14,602.7	78	96,591.8	51,213.4
3	БНД	26	4,595.9	3,819.1	28	4,841.8	4,450.0	54	9,437.7	8,269.1
4	БХД	4	437.3	437.3	13	820.2	820.2	17	1,257.6	1,257.6
5	НД	2	1,270.0	319.8	19	1,010.0	1,010.0	21	2,280.0	1,329.8
6	СБД	88	120,066.3	72,783.0	49	45,914.3	45,914.3	137	165,980.6	118,697.4
7	СХД	25	24,725.4	11,032.7	65	32,319.9	32,319.9	90	57,045.3	43,352.6
8	ХУД	88	111,534.4	48,725.8	30	38,598.4	17,609.8	118	150,132.8	66,335.6
9	ЧД	42	33,130.8	18,207.3	171	46,688.4	43,032.4	213	79,819.2	61,239.7
	Нийт	358	407,158.0	211,034.7	434	212,425.3	186,388.9	792	619,583.3	397,423.6

Дүүргүүдийн хэмжээнд 155,064.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 359 /багцад задарсан/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үүнээс 144,963.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 325 ТАХ-нд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Тайлант онд 517,941.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 929 /багцад задарч нэмэгдсэн/ ТАХ хэрэгжихээс 57.6 хувь буюу 535 ТАХ бүрэн хэрэгжсэн, 31.5 хувь буюу 293 ТАХ хэрэгжих шатанд, 10.9 хувь буюу 101 ТАХ хэрэгжээгүй байна. Гүйцэтгэлээр 544 ТАХ-нд 229,181.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Дүрслэл 1. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал



Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 138 ТАХ (31.8%) зураг төсөв, 101 ТАХ (23.3%) их засвар, 100 ТАХ (23.3%) тоног төхөөрөмж, 51 ТАХ (11.8%) авто зам дэд бүтэц, 19 ТАХ (4.4%) тохижилт, 18 ТАХ (4.1%) барилга байгууламж, 7 ТАХ (1.6%) бусад ангилалд хамаарах ажлууд эзэлж байна.

Аудитын түүврийг хийхдээ МУЕА-ын 2018 оны А/351 дүгээр тушаалын нэгдүгээр дүгээр хавсралтаар баталсан “Гүйцэтгэлийн аудитад түүвэрлэлтийг ашиглах” зааврын дагуу эх олонлогийг бүхэлд нь хамруулах үүднээс 2025 онд хэрэгжсэн ТАХ-ний төсөвт өртөг болон төрөл тус бүрээс хамруулсан. Үүнд:

- Төлөвлөлт: 2025 онд шинээр төлөвлөсөн 212,425.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 434 ТАХ-г бүрэн;
- Худалдан авалт: 478 ТАХ-ээс 156,374.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 245 ТАХ буюу 51.2 хувийг;
- Гэрээний хэрэгжилт: 2025 онд бүрэн дууссан, санхүүжилт олгосон 227,016.1 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 535 ТАХ-ээс 220 буюу 41.2 хувийг;
- Санхүүжилт: Шинээр болон он дамжин хэрэгжсэн 544 ТАХ-нд олгосон 229,181.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн хамруулсан.



БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1. Дүүргүүдийн ИТХ-ын тогтоолоор 2025 онд шинээр 151,275.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 332 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна.

1.2. Төсөв баталсан тогтоолуудад 2-4 удаа нэмэлт өөрчлөлт орж, анх төлөвлөснөөс 61,150.0 төгрөгийн төсөвт өртөгтэй 102 ТАХ-г нэмж, нийт 212,425.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 434 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 2. Дүүргүүдийн 2025 оны батлагдсан төсвийн өөрчлөлтүүд

(сая.төг)

№	Дүүргийн нэр	ДИТХ-ын "2025 оны төсөв батлах тухай"									
		Эхний тогтоол			Сүүлийн тогтоол			Өсөлт / бууралт			
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	
1	БГД	Шинэ	27	23,175.3	23,175.3	32	27,629.6	26,629.6	5	4,454.2	3,454.2
	Он дамжин	32	29,408.7	19,098.8	32	29,408.7	19,098.8	-	-	-	
2	БЗД	Шинэ	24	20,654.8	14,973.3	27	14,602.7	14,602.7	3	(6,052.2)	(370.6)
	Он дамжин	51	82,082.3	36,703.9	51	81,989.2	36,610.8	-	(93.1)	(93.1)	
3	БНД	Шинэ	-	-	-	28	4,841.8	4,450.0	28	4,841.8	4,450.0
	Он дамжин	26	4,595.9	3,819.1	26	4,595.9	3,819.1	-	0.0	-	
4	БХД	Шинэ	5	77.0	77.0	13	820.2	820.2	8	743.2	743.2
	Он дамжин	-	-	-	4	437.3	437.3	4	437.3	437.3	
5	НД	Шинэ	15	855.0	855.0	19	1,010.0	1,010.0	4	155.0	155.0
	Он дамжин	3	1,570.0	619.8	2	1,270.0	319.8	-1	(300.0)	(300.0)	
6	СБД	Шинэ	54	45,199.5	45,199.5	49	45,914.3	45,914.3	-5	714.8	714.8
	Он дамжин	94	115,655.4	68,332.7	88	120,066.3	72,783.0	-6	4,410.9	4,450.3	
7	СХД	Шинэ	34	18,178.8	16,678.8	65	32,319.9	32,319.9	31	14,141.1	15,641.1
	Он дамжин	30	32,290.2	15,597.4	25	24,725.4	11,032.7	-5	(7,564.7)	(4,564.7)	
8	ХУД	Шинэ	29	16,309.8	16,309.8	30	38,598.4	17,609.8	1	22,288.6	1,300.0
	Он дамжин	91	113,638.4	50,025.8	88	111,534.4	48,725.8	-3	(2,104.0)	(1,300.0)	
9	ЧД	Шинэ	144	26,825.1	24,625.1	171	46,688.4	43,032.4	27	19,863.3	18,407.3
	Он дамжин	38	33,491.8	18,134.4	42	33,130.8	18,207.3	4	(361.0)	72.9	
	Дүн	Шинэ	332	151,275.3	141,893.8	434	212,425.3	186,388.9	102	61,150.0	44,495.1
		Он дамжин	365	412,732.6	212,332.0	358	407,158.0	211,034.7	-7	(5,574.6)	(1,297.3)
НИИТ			697	564,007.9	354,225.8	792	619,583.3	397,423.6	95	55,575.3	43,197.8

1.3. Монгол Улсын засаг Захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5¹, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1², 27 дугаар зүйлийн 27.1.1³ дэх заалтыг төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад баримтлах зарчимтай.

1.4. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөхдөө, Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.1⁴, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянан, тайлагнах журам"-ын 3.3.1⁵-д зааснаар шилжих буюу хэрэгжиж буй ТАХ-г нэн тэргүүнд шийдвэрлэхээр тусгагдсан.

1.5. Дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулахдаа зарим дүүргүүд дээрх хууль, журамд заасныг мөрдөж ажиллаагүй байна. Үүнд:

¹ 16.5.Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

² 5.1.Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална:

5.1.2.төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;

5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;

5.1.4.ил тод байдлыг хангасан байх;

5.1.5.хариуцлагатай байх.

³ 27.1.1.төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

⁴ 27.6.1.шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ;

⁵ 3.3.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төсөлд тусгах төсөл, арга хэмжээг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална:

3.3.1.1.шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ;

3.3.1.2.их засвар, арчлалтын төсөл, арга хэмжээ;

3.3.1.3.шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ.



- БНД-ийн ИТХ-ын 2024 оны “Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолд тайлант онд шинээр хэрэгжих ТАХ-г төлөвлөж батлуулаагүй, төсвийн тодотголоор /2025.06.06-ны өдрийн 10 дугаар тогтоол, 25 ТАХ, 2025.12.19-ны өдрийн 22 дугаар тогтоол 4 ТАХ/ шинээр хэрэгжүүлэх ТАХ-г төлөвлөж, баталсан нь Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг мөрдөж ажиллаагүй;
- БХД-ийн ИТХ-ын 2024 оны А/18 дугаар тогтоолоор тухайн жилийн төсвийг төлөвлөж, батлуулахдаа он дамжин хэрэгжих ТАХ-г төсөвт тусгаагүй, төсвийн тодотголоор /2025.04.17-ны өдрийн А/09 дугаар тогтоол/ он дамжин хэрэгжих 4 ТАХ-г төлөвлөж баталсан нь Төсвийн тухай хуульд заасан хариуцлагатай байх зарчмыг мөрдөж ажиллаагүй;
- ЧД-ийн ИТХ-ын 2024 оны 14 дүгээр тогтоолоор тухайн жилийн төсвийг төлөвлөж батлуулахдаа он дамжин хэрэгжих 38 ТАХ-г төсөвт батлуулсан боловч төсвийн тодотголоор /2025.05.21-ний өдрийн 16 дугаар тогтоол/ 9 ТАХ-г нэмэгдүүлж, зарим ТАХ-г хассан нь Төсвийн тухай хуульд заасан хариуцлагатай байх зарчмыг мөрдөж ажиллаагүй;
- СХД-ийн ИТХ-ын 2024 оны 14 дүгээр тогтоолоор 34 ТАХ-г шинээр хэрэгжүүлэхээр баталж, төсвийн тодотголоор /2025.09.05-ны өдрийн 48 дугаар тогтоол/ зарим ТАХ-г хасаж, орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 28 ТАХ-г нэмж баталсан нь Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг мөрдөж ажиллаагүй;
- ХУД-ийн ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор зарим шинэ болон шилжин хэрэгжих ТАХ-ний төсөвт өртгийг тусгахдаа давхардуулан тусгаж, төсөвт өртгийг өсгөсөн нь Төсвийн тухай хуульд заасан төсвийн иж бүрэн бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод, хариуцлагатай байх зарчмуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна. **Хавсралт 1.**

1.6. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁶, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянан, тайлагнах журам”-ын 2.2.4⁷-т “шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт, тооцооллыг гаргаж хавсаргах”-аар заасан.

➤ Гэтэл дүүргийн ЗДТГ-ууд барилга байгууламжийн ангилалд хамаарах 46,866.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-нд зардлын тооцоолол хийхээс 16 ТАХ-ний тооцооллыг хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтгүй байна. **Хавсралт 2.**

Дүрслэл 2. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-ний ангилал

Зураг төсөв 10,257.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 138 ТАХ	Их засвар 38,895.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 ТАХ	Тоног төхөөрөмж 26,033.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ТАХ	Авто зам, дэд бүтэц 35,145.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 51 ТАХ	Төхижилт 12,901.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ	Барилга байгууламж 46,866.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ	Бусад 42,235.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ
--	--	--	--	--	---	--

Шинээр хэрэгжих 212,425.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2025 онд санхүүжих 186,388.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй
434 ТАХ

1.7. ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.1⁸-д “орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах”-аар заасан боловч дүүргүүдийн ЗДТГ холбогдох шалгуур үзүүлэлт, маягт (**хавсралт 1**)-ын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

⁶ 29.2. Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁷ 2.2.4. Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

⁸ 2.3.2.1. орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;



1.8. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2⁹, 67 дугаар зүйлийн 67.3¹⁰-т зааснаар тухайн дүүргийн Засаг дарга иргэдтэй уулзах, нээлттэй хэлэлцүүлэг хийхдээ олон нийтийн оролцоог хангах үүднээс, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын саналыг төсвийн цаглаварт хугацаанд авч, тодорхой хэмжээнд тусгахаар хуульчлагдсан.

➤ Тайланд онд шинээр хэрэгжих ТАХ-нд дээрх саналд үндэслэсэн эсэхийг тулган баталгаажуулахад 169,348.8 (89.0%) сая төгрөгийн төсөвт өртөгтэй 386 ТАХ нийцсэн, 43,076.4 (11.0%) сая төгрөгийн төсөвт өртөгтэй 48 ТАХ нийцээгүй байна. **Хавсралт 3.**

1.9. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7¹¹, 6.8¹²-д заасны дагуу дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжихээр баталсан 212,425.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 434 ТАХ-г дунд хугацааны баримт бичгүүдтэй нийцсэн эсэхийг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

➤ “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д 53,212.6 (30.0%) сая төгрөгийн төсөвт өртөгтэй 130 ТАХ нийцээгүй;
 ➤ “Дүүргүүдийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-т 16,258.7(10.0%) сая төгрөгийн төсөвт өртөгтэй 43 ТАХ нийцээгүй байна. **Хавсралт 4.**

Хүснэгт 3. Хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлсэн байдал

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Үүнээс			
			Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		ДЗД-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр	
			Нийцсэн	Нийцээгүй	Нийцсэн	Нийцээгүй
1	БГД	32	24	8	28	4
2	БЗД	27	12	15	23	4
3	БНД	28	6	22	28	-
4	БХД	13	11	2	11	2
5	НД	19	14	5	14	5
6	СБД	49	46	3	47	2
7	СХД	65	62	3	58	7
8	ХУД	30	14	16	30	-
9	ЧД	171	115	56	152	19
	Нийт	434	304	130	391	43

1.10. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹³-т “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж хуульчилсан боловч өмчид бүртгэх боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 29,386.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.11. Эдгээр төсөл арга хэмжээнүүд нь “*зураг төсөв, техникийн нөхцөл боловсруулах зардал, төрийн байгууллагуудад авто машин худалдан авах, нийтийн орон сууцны дээвэр фасад засвар, цахилгаан шатны шинэчлэлт*” зэрэг ажлууд байна. **Хавсралт 5.**

➤ СБД, “Зураг төсөв, зөвлөх үйлчилгээ худалдан авах, нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад, дээвэр засвар, цахилгаан шатны шинэчлэлт” 11,259.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ;
 ➤ БНД, “Нийтийн зориулалттай орон сууцны гадна фасад, дээвэр засвар, цахилгаан шатны шинэчлэлт” 9,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ;
 ➤ СХД, “Зураг төсөв боловсруулах зардал, дээвэр, фасад засвар, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж” 2,558.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ;
 ➤ ЧД, “Орчны аюулгүй байдал, дэд бүтцийн судалгаа, нийтийн орон сууцуудын гадна фасад, дээвэр засвар” 1,602.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ;

⁹ 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

¹⁰ 67.3.Энэ хуулийн 67.1-д заасан төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга болон хот, тосгоны Захирагч олон нийтэд танилцуулж, тухайн засаг захиргааны нэгжид амьдарч байгаа иргэдийн санал, хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд танилцуулна.

¹¹ 6.7.Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

¹² 6.8.Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.

¹³ 4.1.24.“хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;



- ХУД, “Зураг төсөв, магадлашгүй ажлын зардал, газрын гэрчилгээ, техникийн нөхцөл, хөрөнгө оруулалтын ажилд шаардагдах бусад зардал, төрийн байгууллагын албан хэрэгцээнд автомашин худалдан авах” 997.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 ТАХ;
- БЗД, “Замын цагдаагийн хэлтэс, Прокурорын газар, Татвар, Онцгой байдлын газруудад авто машин худалдан авах” ТАХ, 665.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ;
- НД, “Хүндэтгэлийн гэр, задгай асар, улаан загалмайн байр, автомашин худалдан авах” 485.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ;
- БНД, “2020-2023 оны зураг төсөвтэй ажлуудын төсвийг шинэчлэх” 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ.

1.12. Дүүргүүдийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 186,268,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 418 ТАХ-г нэр байршил нэг бүрээр нь тусгасан боловч 26,156.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-г ерөнхий нэршлээр баталж, хэрэгжүүлэх шатанд тухайн дүүргийн ЗД-ын захирамж, ЗДТГ-ын даргын тушаал шийдвэрээр 101 багцад задалж ТАХ-ний төсөвт өртөг, хэрэгжүүлэх байршлыг тодорхойлсон нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.414-д “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл арга хэмжээ нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгана” гэж заасантай нийцээгүй байна. Үүнд: **Хавсралт 6.**

Дүрслэл 3. ТАХ-г хэрэгжүүлэх шатанд багцад задарсан байдал

БГД	3 ТАХ	11 ТАХ
БЗД	2 ТАХ	5 ТАХ
СБД	5 ТАХ	45 ТАХ
СХД	1 ТАХ	21 ТАХ
ХУД	4 ТАХ	14 ТАХ
ЧД	1 ТАХ	5 ТАХ


✚ *Ерөнхий нэрээр төлөвлөж баталсан 16 ТАХ /101 багц/-ээс 13,252.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ /67 багц/ хөрөнгө оруулалтын бус шинж чанартай “зураг төсвийн зардал, нийтийн орон сууцуудын дээвэр, фасадын ажил, төрийн байгууллагын авто машин тоног төхөөрөмж” ажлууд байна.*

1.13 Ерөнхий нэршлээр баталж, багцад задарсан ТАХ-г хэрэгжүүлэх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Баянгол дүүрэг, Боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах (Steam хөтөлбөр-1) 1,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-г 5 багцад задалсан, багц 2 (Steam хөтөлбөр-2) тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ-ээс сургалтын зардалд зарцуулсан нь “Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1¹⁴-д заасантай нийцээгүй байна.

1.14. Шинээр хэрэгжүүлэх 212,425.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 519 ТАХ-ээс 83,795.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 254 ТАХ (49.0%) төсөвлөлтийн шаардлага хангаагүй /төсөв батлагдсаны дараа холбогдох шийдвэрүүд нь гарсан/ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁵-д “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, магадлалаар баталгаажсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана” гэж заасантай нийцээгүй байна. **Хавсралт 7**

Дүрслэл 4. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй батлагдсан ТАХ



1.15. Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний бэлтгэл ажлыг бүрэн хангаагүй, төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй ТАХ-г төсөвт тусган батлуулж, хэрэгжүүлэх шатанд зураг төсөв, техникийн нөхцөлийг боловсруулж, магадлалаар баталгаажуулж байгаа нь төсөвт өртөг өөрчлөгдөх, ТАХ зорилтод үр дүндээ хүрэхгүй байх, он дамжин хэрэгжих эрсдэлийг үүсгэж байна.

¹⁴ 27.1.1.төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

¹⁵ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.



Хүснэгт 4. Төсөв баталсан тогтоолын өөрчлөлт

(сая.төг)

№	Дүүрэг	Өсгөсөн / Бууруулсан	Шинэ / Шилжих	ТАХ тоо	Эхний тогтоол		Сүүлийн тогтоол		Зөрүү	
					Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	БЗД	Өсгөсөн	Шинэ	4	5,630.0	3,130.0	5,794.9	5,794.9	164.9	2,664.9
			Шилжих	1	1,750.0	1,130.8	1,933.0	1,313.8	183.0	183.0
		Бууруулсан	Шилжих	1	1,057.6	1,057.6	781.4	781.4	(276.1)	(276.1)
2	БНД	Өсгөсөн	Шинэ	1	729.1	749.1	749.1	749.1	20.0	-
		Бууруулсан	Шинэ	4	334.8	334.8	314.8	314.8	(20.0)	(20.0)
3	НД	Өсгөсөн	Шинэ	1	70.0	70.0	90.0	90.0	20.0	20.0
			Шинэ	1	150.0	150.0	249.4	249.4	99.4	99.4
4	СБД	Өсгөсөн	Шилжих	2	6,005.4	4,127.0	6,426.9	4,588.0	421.5	460.9
5	СХД	Өсгөсөн	Шинэ	4	12,129.4	10,629.4	24,035.4	24,035.4	11,906.0	13,406.0
6	ХУД	Өсгөсөн	Шинэ	2	2,282.4	2,282.4	3,128.3	3,128.3	845.9	845.9
		Бууруулсан	Шинэ	1	2,000.0	2,000.0	1,978.4	1,978.4	(21.6)	(21.6)
7	ЧД	Өсгөсөн	Шинэ	4	8,401.1	8,401.1	17,469.2	17,469.2	9,068.2	9,068.2
			Шилжих	1	5,200.0	3,200.0	5,200.0	3,688.0	-	488.0
			Шинэ	15	5,510.0	3,310.0	4,962.0	1,962.0	(547.9)	(1,347.9)
		Бууруулсан	Шилжих	1	344.0	344.0	344.0	250.0	-	(94.0)
			Шинэ	17	29,392.0	25,412.0	51,516.3	51,516.3	22,124.3	26,104.3
Дүн		Өсгөсөн	Шинэ	4	12,955.4	8,457.8	13,559.9	9,589.7	604.5	1,131.9
			Шилжих	4	7,844.7	5,644.7	7,255.1	4,255.1	(589.6)	(1,389.6)
		Бууруулсан	Шинэ	20	7,844.7	5,644.7	7,255.1	4,255.1	(589.6)	(1,389.6)
			Шилжих	2	1,401.6	1,401.6	1,125.4	1,031.4	(276.1)	(370.1)
НИИТ				43	51,593.7	40,916.1	73,456.8	66,392.6	21,863.1	25,476.5

Дүүргүүдийн 2025 оны төсөв баталсан тогтоолд орсон нэмэлт өөрчлөлтөөр шинэ болон шилжин хэрэгжих 21 ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг 0.8-10,890.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 22 ТАХ-ний санхүүжих дүнг 9.7-800.0 сая төгрөгөөр бууруулж баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6¹⁶, 42 дугаар зүйлийн 42.7¹⁷-д заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

1.16. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-г магадлалаар баталгаажуулснаас 9 ТАХ-ний батлагдсан төсөвт өртөг 0.8-832.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

- ЧД, “Чингэлтэй эцсийн буудлаас Зүрх уулын фитнес хүртэлх авто зам, гэрэлтүүлгийн ажил” (23 дугаар хороо) ТАХ, 832.2 сая төгрөг;
- ХУД, “Сод монгол ШТС-с ИНЕГ хүртэлх авто зам засварын ажил” (21 дүгээр хороо) ТАХ, 502.6 сая төгрөг;
- ХУД, “7 дугаар хэсгийн авто замын ажил” (13 дугаар хороо) ТАХ, 343.5 сая төгрөг;
- БЗД, “Засаг даргын Тамгын газрын хуралдааны танхимын засварын ажил” ТАХ, 100.0 сая төгрөг;
- СБД, “8-р хороо, 14/4-р байрны дээвэр засварын ажил” ТАХ, 99.4 сая төгрөг;
- БЗД, “17 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгын гадна инженер шугам сүлжээний ажил” ТАХ, 64.0 сая төгрөг;
- СХД, “170 дугаар цэцэрлэгийн барилгын ариутгах татуургын ажил” ТАХ, 15.7 сая төгрөг;
- ЧД, “15 дугаар байрны фасад засварын ажил” (1 дүгээр хороо) ТАХ, 4.0 сая төгрөг;
- БЗД-ийн “Соёлын ордны барилгын дээвэр засварын ажил” ТАХ, 0.8 сая төгрөг.

1.17. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ-нд техникийн тодорхойлолт боловсруулснаас 5 ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүн 20.0-2,500.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

- БЗД, “Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын асфальт бетоны үйлдвэрийн барилгын ажил” ТАХ, тайланд онд санхүүжих дүн 2,500.0 сая төгрөг;
- СХД, “Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдаж авах”, тайланд онд санхүүжих дүн 1,500.0 сая төгрөг;
- ЧД, “Цэргийн штабын албан хэрэгцээнд автомашин худалдан авах” ТАХ, төсөвт өртөг 65.0 сая төгрөг;
- БНД, “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж худалдан авах” ТАХ, төсөвт өртөг 20.0 сая төгрөг;
- НД, “Улаан загалмайн байрыг худалдан авах” ТАХ, төсөвт өртөг 20.0 сая төгрөг.

1.18. Дараах хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ТАХ-г хэрэгжүүлэх явцад батлагдсан төсөвт өртөг нь 1,000.0-10,890.3 нэмэгдсэн байна. Үүнд:

- СХД, “Газар чөлөөлөлтийн ажил” ТАХ, 10,890.3 сая төгрөг;

¹⁶ 29.3.6.тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

¹⁷ 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.



- ЧД, “Газар чөлөөлөлтийн ажил” ТАХ, 8,167.0 сая төгрөг;
- СХД, “Зураг, төсөв боловсруулах зардал” ТАХ, 1,000.0 төгрөг.

1.19. Тайланд онд шинээр хэрэгжих болон шилжин хэрэгжих ТАХ-ний санхүүжих дүнг бууруулж баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6¹⁸-д “*тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх*” гэж заасантай нийцээгүй байна. **Хаасралт 8.Үүнд:**

Шинээр хэрэгжих • 7,844.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 20 ТАХ

Шилжин хэрэгжих • 1,401.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2 ТАХ

Шинээр хэрэгжих:

- ЧД, “Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын гадна инженерийн шугам сүлжээний ажил” ТАХ, 800.0 сая төгрөг;
- ЧД, “Авто замын борооны ус зайлуулах шугамын ажил” (2, 4, 6 дугаар хороо) ТАХ, 340.0 сая төгрөг;
- ХУД, “Газар чөлөөлөлтийн зардал” ТАХ, 21.6 сая төгрөг;
- БНД, “Нийслэлийн хүүхдийн 131 дүгээр цэцэрлэгийн их засварын зураг төсөв боловсруулах ажил” ТАХ, 9.7 сая төгрөг.

Шилжин хэрэгжих:

- ЧД, “Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Хүүхдийн амбулаторийн барилгын засварын ажил” ТАХ, 344.0 сая төгрөг;
- БЗД, “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн (Ай Жи Эм)-ийн тохижилт, барилгын ажил” (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 23, 28 дугаар хороо) ТАХ, 276.1 сая төгрөг.

1.20. Зарим шилжин хэрэгжих ТАХ-нд төсвийн тодотголоор санхүүжих дүнг 39.4-488.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Үүнд:

- ЧД, “Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн салбар ангийн барилга барих ажил” ТАХ, 488.0 сая төгрөг;
- СБД, “7-р хороо, нийтийн зориулалттай орон сууцны фасад засварын ажил” ТАХ, 421.5 сая төгрөг;
- БЗД, “Тохижилтын ажил” (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 27 дугаар хороо) ТАХ, 183.0 сая төгрөг;
- СБД, “75-р цэцэрлэг өргөтгөл барилгын ажил” ТАХ, 39.4 сая төгрөг.

1.21. Тайлант онд хэрэгжиж дуусах 15,998.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 ТАХ-ний гэрээг 2025 оны 10 дугаар сараас хойш байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4¹⁹-т заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэлт: Төсөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г төлөвлөж батлуулаагүй, төсвийн тодотголоор шинэ болон шилжих ТАХ-ний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчилсөн, төсвийн зарчмыг мөрдлөг болгоогүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

¹⁸ 29.3.6.тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

¹⁹ 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;



БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.

2.1. Дүүргүүдийн 3Д нар ХАА-г зохион байгуулах захирамж гаргахдаа 434 ТАХ-г нэршил, байршил, хүчин чадал зэргийг харгалзан 519 ТАХ болгон багцад хуваажээ.

2.2. Тайлант онд 198,226.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 478 ХАА-г зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

2.3. Нийт ТАХ-ний 59.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалт, 30.0 хувийг харьцуулалтын аргаар, 11.0 хувийг шууд худалдан авалтаар зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 5. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан арга (сая.төг)

№	Дүүргийн нэр	Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Шууд худалдан авах	
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг
1	БГД	35	32,176.4	6	560.0	-	-
2	БЗД	24	13,618.6	3	300.0	-	-
3	БНД	12	3,226.7	15	1,762.6	7	166.5
4	БХД	4	918.2	5	299.1	7	98.4
5	НД	4	1,565.0	13	645.0	3	60.0
6	СБД	69	66,236.2	52	4,099.7	-	-
7	СХД	16	8,086.2	15	1,117.1	-	-
8	ХУД	29	34,697.0	6	485.7	-	-
9	ЧД	88	25,070.8	29	2,460.5	36	576.5
Нийт		281	185,595.1	144	11,729.7	53	901.4

2.4. Харин 2,794.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ-ний ХАА амжилтгүй болсон нь дараах шалтгаантай байна. Тухайлбал:

- Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, техникийн тодорхойлолтгүй, төсвийн тодотголоор шинэ ТАХ-г баталсан, эрх шилжүүлэхэд хугацаа алдсанаас 612.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ-ний хөрөнгө татагдсан;
- ХАА зарласан боловч оролцогчгүйгээс он дамжин үргэлжилж буй 1,147.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ.

2.5. Төрийн хэмнэлтийн тухай 13 дугаар зүйлийн 13.1.1²⁰, 13.1.2²¹-д “...худалдан авах ажиллагаа 05 дугаар сарын 31-ний дотор дуусгаж, дуусаагүй ТАХ-ний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцно” гэж заасны дагуу дүүргүүд 11,404.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ-г хуульд заасны дагуу зогсоосон байна.

2.6. Гэвч зарим дүүргүүд дээрх хугацааг баримтлалгүй, хуулиар тогтоосон хугацаанаас хойш 21,911.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 79 ХАА-г зохион байгуулсан нь төсвийн жилийн дундуур төсөвт тодотгол хийж, шинэ ТАХ нэмж баталсантай холбоотой байна. Үүнд:

Хүснэгт 6. ХАА-г 2025 оны 05 дугаар сарын 31-ээс хойш зохион байгуулсан (сая.төг)

№	Дүүргийн нэр	ХАА-нд мөрдөгдсөн журам						Нийт ТАХ-ний тоо	Нийт төсөвт өртөг
		Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалт		Шууд худалдан авах			
		ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг		
1	БГД	4	4,304.2	1	150.0	-	-	5	4,454.2
2	БНД	4	1,366.6	10	1,442.6	1	49.5	15	2,858.7
3	БХД	-	-	1	45.0	1	19.0	2	64.0
4	НД	-	-	1	100.0	-	-	1	100.0
5	ЧД	13	13,458.1	8	417.3	35	559.5	56	14,434.9
Нийт		21	19,128.9	21	2,154.9	37	628.0	79	21,911.8

2.7. ХАА-г зохион байгуулахдаа зарим дүүргүүд ТББ-г захиалагчаар батлуулаагүй, үнэлгээний хороо байгуулагдаагүй байхад ТББ-г батлуулсан, тендерийн баталгааг хуульд

²⁰ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

²¹ 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;



заасны дагуу тооцоогүй, батлагдсан төсөвт багтаан хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна. Тухайлбал:

БЗД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- 12,195.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ-г захиалагчаар батлуулаагүй, ХААА-ны дарга ТББ-г баталсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.5-д заасантай нийцээгүй;
- Дээрх ажлуудын үнэлгээний хороо байгуулагдаагүй байхад "ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх мэдээдэл"-ийг бөглөж баталгаажуулсан;
- "Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил"-ын гүйцэтгэгчийг сонгох үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд ашиглагч байгууллагын төлөөллийг оролцуулсан.

СХД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- Хот тохижилтын техник хэрэгсэл худалдаж авах 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг зохион байгуулах явцад гомдол гарч, СЯ-аас 2024 оны 03/10852 тоот албан бичгээр тендер сонгон шалгаруулалтыг зогсоох, 2025 оны 03/295 тоот албан бичгээр үнэлгээг дахин хянахыг зөвлөсөн боловч өмнөх оролцогчтой гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2.1-д заасантай нийцээгүй;
- "Автобусны зогсоол 6 байршилд шинээр байгуулах" 630.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТАХ-ний захиалагч ажлын даалгаврыг 1 байршлаар дутуу ирүүлсэн, үнэлгээний хороо тендерийг зарлахдаа магадлалаар баталгаажсан төсвийн дагуу зарлаагүй;
- "Техник хэрэгсэл худалдаж авах (Захиалагчийн алба ОНӨААТҮГ)" 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хороо хуульд заасан чиг үүргийн дагуу ТББ-г захиалагчаар баталгаажуулаагүй;
- "Усан сан барих ажил (23 дугаар хороо)" ТАХ-г батлагдсан төсвийн хүрээнд зарлаагүй, нэгтгэн зарласан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2.1-д заасантай нийцээгүй.

БГД-ийн ХААА-аас зохион байгуулсан:

- "Гэр хороолол дахь автомашины гүүр шинэчлэх ажил" (21-р хороо)-ыг зохион байгуулах үнэлгээний хороо тендерийг дахин зарлахдаа ТББ-г захиалагчаар батлуулаагүй;
- "Тусгай зориулалтын техник тоног төхөөрөмж хэрэгсэл худалдан авах" тендерийг хуулийн хүрээнд зохион байгуулсан боловч захиалагч хуульд заасан хугацаанд гэрээ байгуулаагүй.

ЧД-ийн ХАА-ны албанаас зохион байгуулсан:

- 1,188.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9 ТАХ-г захиалагчаар батлуулаагүй, огноо дугаар гарын үсгээр баталгаажуулаагүй.

2.8. ЧД-ийн ХААА-наас тендерийг цахимаар зарлахдаа урсгал зардал болон орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх ТАХ-ний санхүүжих эх үүсвэрийг дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт гэж зарлаж, үр дүнг нийтэлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1²²-т заасантай нийцээгүй байна. Үүнд:

- "Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ" ТАХ;
- "Хот нийтийн аж ахуйн ажил буюу хог хаягдал тээвэрлэлт" ТАХ;
- "Гэрэлтүүлгийн ашиглалт" ТАХ;
- "Ногоон байгууламжийн арчилгаа" ТАХ;
- "Нохой, муур устгал" ТАХ.

2.9. Зарим үнэлгээний хороод "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам"-д заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.2²³, 50 дугаар зүйлийн 50.10²⁴-д заасантай тус тус нийцээгүй байна.

- ЧД-ийн 2,879.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 11 ТАХ-ний үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зарим ажилд нээлтийн тэмдэглэл, холбогдох маягтууд дутуу, бөглөөгүй;
- "Алслагдсан хороодод үйлчлэх автобус /2/" ТАХ-ний ХАА-г зарлахдаа тендерийн баталгааг зөрүүтэй тооцсон, тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлээгүй, шалгараагүй оролцогчдод мэдэгдлийг хүргүүлэхдээ зөв хүргүүлээгүй;

²² 9.1.Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

²³ 28.2.Энэ хуулийн 28.1.2, 28.1.3-т заасан шийдвэрт түүний тендер шалгараагүй, эсхүл татгалзсан үндэслэлийг болон гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнэ зэргийг зааж оролцогч тус бүрд нэгэн зэрэг мэдэгдэнэ

²⁴ 50.10.Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлох, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ.



- СБД, “1-р хороо, 16 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын нэмэлт санхүүжилт”-ийн ажлын үнэлгээний хорооны /2025.05.29/ хурлаар ТХТХ-д заасны дагуу ХАА-г зогсоохоор шийдвэрлэсэн боловч үргэлжлүүлэн зохион байгуулсан;
- СБД, “11-р хороо, 506 байрны орчим цэцэрлэг рүү зам тавих” ТАХ-г зохион байгуулах үнэлгээний хороо ТШӨХ-д машин механизмыг “усны машин, ачааны машин” болгон өөрчлөлт оруулсан боловч захиалагчаар батлуулаагүй;
- БГД, “Явган шат, явган хүний зам засварын ажил” ТАХ-г зохион байгуулах үнэлгээний хороо ТББ-г захиалагчаар 2 удаа батлуулсан боловч хурлын тэмдэглэлгүй;
- БЗД, “Соёлын ордонд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил” (Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг), ТАХ-г зохион байгуулах үнэлгээний хороо цахимд тендер сонгон шалгаруулалтыг зарлаж техникийн тодорхойлолтод өөрчлөлт оруулахаар хугацааг хойшлуулсан боловч өөрчлөлт оруулаагүй;
- ХУД, “Монгол хэл, гадаад хэлний кабинет байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж худалдан авах ажил” ТАХ-г зохион байгуулах үнэлгээний хороо шалгарсан болон шалгараагүй оролцогчийн мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлээгүй.

2.10. ТББ-ийг боловсруулахдаа санхүүгийн чадавхыг өндөр шаардсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1²⁵, 16 дугаар зүйлийн 16.2.3²⁶-т заасантай тус тус нийцээгүй байна. Тухайлбал:

- БГД, “Хог тээврийн тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах” ТАХ;
- БЗД, “Баянзүрх дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад шаардлагатай хүүхдийн хөгжлийн хавтас нийлүүлэлтийн ажил” ТАХ;
- БГД, “Татварын хэлтсийн албан хэрэгцээнд автомашин худалдан авах” ТАХ.

2.11. Дүүргүүдийн хэмжээнд 40,378.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 42 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-д “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасантай нийцээгүй байна. Тухайлбал: **Хавсралт 10.**

Хүний нөөц, ажиллах хүчний шаардлага хангаагүй:

- ЧД, “Хороодод Ухаалаг хогийн сав байрлуулах ажил” (1,3,4,5,6,10 дугаар хороо), шалгарсан оролцогч Грейтроуд ХХК, ерөнхий инженер нь барилгын инженер шаардсан боловч барилгын бүтээц эдлэлийн технологич мэргэжилтэй;
- БЗД, “Усан спорт сургалтын төв ОНӨААТҮГ-т шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлт, засварын ажил”, шалгарсан оролцогч Сандо Тэнга инженеринг ХХК, халаалт агаар сэлгэлтийн инженер шаардсан боловч хүрээлэн буй орчны инженер мэргэжилтэй;
- СХД, “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын дотоод агаарын чанарыг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”, шалгарсан оролцогч Ривади Од ХХК, тоног төхөөрөмж нийлүүлэлт, суурилуулалт, гүйцэтгэлийн хариуцсан баг ажиллуулахаар шаардсан боловч “хөлсөөр ажиллуулах” гэрээтэй 1 инженертэй;
- БГД, “Замын эгнээ тусгаарлах хашаа хайс байрлуулах ажил”, шалгарсан оролцогч Нанодизель трейд ХХК, цахилгааны инженер шаардсан боловч уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалтын инженертэй;
- БЗД, “Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил”, шалгарсан оролцогч Микросити ХХК, тоног төхөөрөмжийн инженер “IT инженер эсхүл Сүлжээний инженер” мэргэжилтэй 2 ажилтан шаардсан боловч аялал жуулчлалын менежмент, цаг уурч, компьютерын программ хангамжийн мэргэжилтэй;
- СХД, “Явган замын хайс хийх ажил”, шалгарсан оролцогч Нано дизель трейд ХХК, хүний нөөцийн ажилласан жилийн туршлага, нийгмийн даатгалын лавлагаа, тодорхойлолт шаардлага хангаагүй;
- НД, “1 дүгээр хороо Уурхайчдын гудамжнаас Баянзүрхийн 16 дугаар гудамжны зүүн талд хүртэл автозамын зураг төсөв боловсруулах”, шалгарсан оролцогч Гео урбан консалтинг ХХК, зургийн техникч шаардсан боловч авто зам барилгын инженертэй.

Техникийн нөхцөлийн шаардлага хангаагүй:

- СХД, “Хог тээврийн тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах”, шалгарсан оролцогч Сүвэн-Уул ХХК, хөдөлгүүрийн загвар Dongfeng Cummins гэж шаардсан боловч Sany марк,

²⁵ 15.1.Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана.

²⁶ 16.2.3.сүүлийн гурав хүртэл жилийн хугацаанд оролцогчийн хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогын мэдээлэл.



- хөдөлгүүрийн төрлийг QSB6.7-C215 шаардсан боловч D07S3-245EO, хөдөлгүүрийн чадал 158 кВт/2000эрг/мин шаардсан боловч 180кВт/2000эрг/мин, явах хурд 4.5км/цаг шаардсан боловч 2.4 км/цаг, бүх талаас нь авсан фото зураг ирүүлэхийг шаардсан боловч брошюр зураг ирүүлсэн;
- СХД, “Техник хэрэгсэл худалдаж авах (Захиалагчийн алба ОНӨААТҮГ)”, шалгарсан оролцогч Ганбүрэн ХХК, оролцогчийн гаалийн бичиг, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээ, баталгаат орчуулга, бүх талаас авсан фото зураг ирүүлнэ гэж шаардсан боловч тус баримт бичгийг ирүүлээгүй, фото зураг бүрэн ирүүлээгүй;
 - БГД, “Явган шат, явган хүний зам засварын ажил”, шалгарсан оролцогч Антек ХХК, ачааны авто машин 1.5 тн даацтай байхыг шаардсан боловч 1 тн даацтай авто машины санал ирүүлсэн;
 - НД, “Усны машин худалдан авах”, шалгарсан оролцогч Арби элеваторс ХХК, техникийн тодорхойлолтод заасан "CIP" цэвэрлэх төхөөрөмжөөр тоноглогдсон байхыг шаардсан боловч ирүүлээгүй;
 - НД, “Хүндэтгэлийн гэр худалдан авах”, шалгарсан оролцогч Зүүнсайн ХХК, техникийн тодорхойлолтод модны хаталт 14-16 хувь гэж шаардсан боловч 12.5 хувьтай ирүүлсэн;
 - НД, “Автомашин худалдан авах”, шалгарсан оролцогч УАЗ Мега ХХК, техникийн тодорхойлолтод автомашины үйлдвэрлэсэн огноог 2019 гэж шаардсан боловч 2017 оны автомашин нийлүүлсэн.
 - БГД, “Татварын хэлтсийн албан хэрэгцээнд автомашин худалдан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн албан хэрэгцээнд автомашин худалдан авах ажил”, шалгарсан оролцогч Монгол Хьюндай автомотив ХХК, техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг хангаагүй.

Ижил төстэй ажил хэрэгжүүлсэн туршлагын шаардлага хангаагүй:

- БГД, “Гэр хороолол дахь автомашины гүүр шинэчлэх ажил (21-р хороо)”, шалгарсан оролцогч Хайрхан уулын зам ХХК, гүүр, гүүрэн байгууламжийн үндсэн гүйцэтгэгчээр ажиллаагүй;
- БЗД, “Дэд бүтцийн ажил (БЗД 16-р хороо)”, шалгарсан оролцогч Батлюкс ХХК, “дэд бүтэц”-ийн үндсэн гүйцэтгэгчээр ажиллаагүй;
- СХД, “125 дугаар цэцэрлэгийн гадна фасад засвар (30 дугаар хороо)”, шалгарсан оролцогч Өвөлжөөн булаг ХХК, гадна фасадны үндсэн гүйцэтгэгчээр ажиллаагүй;
- БЗД, “Баянзүрх дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад шаардлагатай хүүхдийн хөгжлийн хавтас нийлүүлэлтийн ажил”, шалгарсан оролцогч Ю Эс Эс фэйс ХХК, ижил төстэй ажлын шалгуур хангаагүй;
- БХД, “Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашин худалдаж авах”, шалгарсан оролцогч Топ моторс ХХК, ижил төстэй ажлын гэрээний орчуулгыг ирүүлээгүй.

Санхүүгийн чадавхын шаардлага хангаагүй:

- БЗД, “Улаанбаатар зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын асфальт бетоны үйлдвэрийн тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил” багц-2, шалгарсан оролцогч Ундрах-Эхлэл ХХК, түргэн хөрвөх хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээг батлагдсан төсөвт өртгийг 30 хувиас багагүй байх.

Тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй:

- ЧД, “Дүүргийн 30 дугаар байрны фасад засвар 6 дугаар хороо”, шалгарсан оролцогч Хэрмээдэй ХХК, барилга хот байгуулалтын яамнаас олгосон тусгай зөвшөөрөлд БА-7.1 байхгүй.

Шийдвэрлэлт: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.



БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙГЭЭС ТӨЛӨВЛӨСӨН ХУГАЦААНДАА ЧАНАРТАЙ, ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА.

3.1. Тайланд онд дүүргүүдийн хэмжээнд он дамжих болон шинээр хэрэгжих нийт 619,583.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 517,941.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй, 929 ТАХ-г хэрэгжүүлсэн байна. Үүнээс 535 ТАХ (57.6%) бүрэн хэрэгжсэн, 293 ТАХ (31.5%) хэрэгжих шатанд, 101 ТАХ (10.9%) хэрэгжээгүй байна.

Хүснэгт 7. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

(сая.төг)

Д/д	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан ажил		Хэрэгжилт дутуу, он дамжин хэрэгжиж байгаа		Хэрэгжээгүй	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	70	57,038.3	52,654.4	47	26,372.3	18	26,282.2	5	-
2	БЗД	81	96,591.8	95,530.1	39	45,896.5	38	48,852.1	4	781.5
3	БНД	54	9,437.7	7,885.1	26	4,135.9	20	3,729.2	8	20.0
4	БХД	17	1,257.6	1,183.9	14	989.2	3	194.7	-	-
5	НД	21	2,280.0	2,217.1	14	2,033.3	6	183.8	1	-
6	СБД	202	165,980.6	137,905.7	151	57,285.7	44	80,620.1	7	-
7	СХД	129	57,045.3	48,180.1	84	34,826.3	19	13,273.8	26	80.0
8	ХУД	128	150,132.8	118,533.0	73	34,024.1	36	84,303.7	19	205.3
9	ЧД	227	79,819.2	53,851.5	87	21,452.9	109	32,350.4	31	48.2
Нийт		929	619,583.3	517,941.0	535	227,016.1	293	289,790.0	101	1,135.0

3.2. Хэрэгжээгүй ТАХ нь ажлын даалгавар, техникийн тодорхойлолт зөрүүтэй, магадлалын дүгнэлт удааширсан, худалдан авах ажиллагаанд оролцогчгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд амжаагүй, төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан зэргээс шалтгаалжээ.

3.3. Хэрэгжилт дутуу, он дамжин хэрэгжиж байгаа ТАХ-ний зураг төсөв болон гүйцэтгэгч сонгон шалгаруулалт удааширсан, технологийн зогсолт хийсэн, захиалагч гэрээг тухай бүр дүгнээгүй зэрэг шалтгаанаар он дамжин хэрэгжиж байна.

3.4. Тайлант онд хэрэгжүүлсэн ТАХ-г ангилбал, их засварын 138 ТАХ (26.0%), тоног төхөөрөмж, машин механизм, техник хэрэгсэл 132 ТАХ (25.0%), зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах 116 ТАХ (22.0%), тохижилт, бүтээн байгуулалтын 55 ТАХ (10.0%), барилга байгууламжийн 25 ТАХ (5.0%), авто зам, дэд бүтцийн 62 ТАХ (2.0%) бусад ангилалд хамаарах 7 ТАХ (1.0%) байна.

3.5. Хэрэгжсэн болон хэрэгжиж буй ТАХ-ээс аудитын түүвэрт ангилал, төрлөөс хамааран 189,018.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 220 ТАХ-г хамруулан шалгахад зураг төсөвт тусгагдсан ажлууд хийгдээгүй, чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй, тооцоо судалгааг үндэслэлтэй хийж хэрэгжүүлээгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлыг төлөвлөсөнтэй холбоотой илэрсэн зөрчлүүд, тухайлбал:

- СХД, “Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдаж авах”, гүйцэтгэгч Сүвэн уул ХХК, гэрээний дүн 2,893.4 сая төгрөг, Асфальтын үйлдвэрийн суурийн ажил төсөвт тусгагдаагүй, оффисын байр, моторын суурийн бетон цутгаагүй, суурийг бэхлээгүй, цахилгааны утас далдлагчийг бүрэн хийгээгүй, шаардлагад нийцсэн ёонкос суурилуулаагүй;
- ЧД, “Хороодод Ухаалаг хогийн сав” байршуулах ажил (1-24 дүгээр хороо), гүйцэтгэгч Грэйт роуд ХХК, гэрээний дүн 1,493.1 сая төгрөг, хэрэгцээ шаардлагыг бүрэн тооцоолоогүй, тооцоо судалгаагүй, нийтийн зориулалтаар төлөвлөөгүй;
- ХУД, “Нисэхийн эцсийн авто зам дагуух тохижилтын ажил” (16, 25 дугаар хороо), гүйцэтгэгч Байгаль Алтай ХХК, гэрээний дүн 885.4 сая төгрөг, холбогдох байгууллагуудтай зөвшилцөөгүйгээс гүйцэтгэсэн ажлын явган замын хавтанг хуулж эвдэлсэн;
- СБД, “Сургууль, цэцэрлэгийн материаллаг бааз бэхжүүлэх” Багц-2 “16, 281, 248 дугаар цэцэрлэгийн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад хангамжийн материал худалдаж авах ажил”, гүйцэтгэгч Санаа мед трейд ХХК, гэрээний дүн 564.8 сая төгрөг, 16-р



цэцэрлэгийн барилга угсралтын ажил дуусаагүй байхад 267.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хангамжийн материал бэлтгэсэн;

- НД, “Улаан загалмайн байрыг худалдан авах” гүйцэтгэгч ЦОМА ХХК, гэрээний дүн 90.0 сая төгрөг, хэрэгцээ шаардлагыг тодорхойлоогүй, тооцоо судалгаагүй.

Зураг 1. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүй ТАХ



Тайлбар: СХД, “Асфальтын үйлдвэр барих, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил”, суурийн ажил төлөвлөөгүйгээс суурийн ажил ажил хийгдээгүй, стандартын дагуу гүйцэтгээгүй.



Тайлбар: ХУД, Нисэхийн эцсийн авто зам, тохижилтын ажил, төсөвлөлтийн шаардлага хангаагүйгээс ажил гүйцэтгээдсэний дараа цахилгааны шугам татаж хуулсан



Захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зураг төсөв, техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлыг тоо хэмжээ, зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй, чанартай гүйцэтгээгүй дараах зөрчлүүд байна, тухайлбал:

- СХД, “Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга” (10 дугаар хороо), гүйцэтгэгч Элбэггүн ХХК, гэрээний дүн 1,910.4 сая төгрөг, 1, 2 дугаар давхрын зарим өрөөний хана цуурсан, орчны ногоон байгууламжийн ажил хийгдээгүй, замын бродюрын чигжээс бүрэн хийгдээгүй;
- ХУД, “Цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай, зам талбайн тохижилтын ажил 2 дугаар үе шат (21 дүгээр хороо), гүйцэтгэгч Гарденсити ХХК, гэрээний дүн 1,415.8 сая төгрөг, хүүхдийн савлуурын хамгаалалт труба хаалт хийгдээгүй, ногоон байгууламжийн ажил бүрэн хийгдээгүй байхад комисс хүлээн авсан;
- БГД, “Бага сургууль цэцэрлэгийн гадна тохижилтын ажил”, гүйцэтгэгч Шонхорчин ХХК, гэрээний дүн 686.6 сая төгрөг, төсөвт тусгагдсан хүүхдийн тоглоомын савлуурыг байршуулаагүй;
- СБД, “10-р хороо, 13, 15, 30, 30б, 36-р байрны гадна талын авто зогсоол, явган зам талбайн тохижилт”, гүйцэтгэгч Эм эм роуд бридж ХХК, гэрээний дүн 586.1 сая төгрөг, явган замын чигжээс, хашлага, бродюрыг бүрэн хийгээгүй, орчны үүдний довжоо эвдрэлтэй, зогсоолын усны хаялга бетон төмрийг зурагт заасны дагуу хийгээгүй, сандлыг бүрэн байршуулаагүй, хүүхдийн тоглоомын савлуур байршуулаагүй;
- ЧД, “Алслагдсан хороодод үйлчлэх автобус” /2/, нийлүүлэгч Жаргалант транспортны экспедитор ХХК, гэрээний дүн 585.0 сая төгрөг, нийлүүлсэн “County” маркийн автобусны суудлын тоо болон км-ийн гүйлт шалгуур хангаагүй;
- БГД, “Явган шат, явган хүний зам засварын ажил”, гүйцэтгэгч Антек ХХК, гэрээний дүн 459.8 сая төгрөг, 2 байршилд хийж гүйцэтгэсэн явган замын ажил дутуу, зарим хэсэгт эвдэрч суулт өгсөн, стандартын дагуу хийж гүйцэтгээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөч хавтангийн эхлэл төгсгөл байхгүй, ажлын тоо хэмжээнд тусгагдсан явган замыг хавтанг асфальтаар хийсэн;
- БНД, “Төрийн байгууллагуудад шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж худалдан авах”, гүйцэтгэгч Би Си Ти ХХК, гэрээний дүн 348.8 сая төгрөг, техникийн тодорхойлолтод заасан суурин компьютер нийлүүлээгүй, загварыг сольсон;
- НД, “Усны машин худалдан авах ажил” гүйцэтгэгч Арби элеваторс ХХК, гэрээний дүн 178.3 сая төгрөг, автомашины ёнкосний багтаамж 2000тн.оор бага;
- БНД, “Теле камерын хяналтын төвд шуурхай ажиллагаа, засварын автомашин худалдан авах” гүйцэтгэгч Энержи бөх бат ХХК, гэрээний дүн 159.0 сая төгрөг, нийлүүлсэн “JINBELSY” маркийн бага багтаамжийн автобусны хөдөлгүүр 200СС-ээр дутуу мотортой, “JMC” маркийн тусгай зориулалтын крантай авто машины 4 ширхэг өвлийн дугуйг хүлээн аваагүй;
- БЗД, “Багц-2 Прокурорын газарт шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил” гүйцэтгэгч ВМВ СОР ХХК, гэрээний дүн 129.5 сая төгрөг, автомашины үйлдвэрлэсэн он шалгуур хангаагүй;
- НД, “Автомашин худалдан авах ажил”, гүйцэтгэгч УАЗ мега ХХК, гэрээний дүн 99.4 сая төгрөг, автомашины үйлдвэрлэсэн он болон дотор салоны шаардлагад нийцээгүй;
- СХД, “Ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбайн тохижилт”, гүйцэтгэгч Шүрэн гоёл ХХК, гэрээний дүн 98.7 сая төгрөг, хүүхдийн тоглоомын талбайн резинэн будаг хуурсан, зогсоолын тэмдэглэгээ хийгээгүй, зураг төсөвт тусгагдсан усны хаялгыг өөрчилсөн;



- НД, “3 дугаар хороо, Малчдын шинэ суурьшлын бүсэд худгийн барилга барих ажил”, гүйцэтгэгч Сэргэлт иргэдийн бүлэг, гэрээний дүн 20.0 сая төгрөг, худгийн барилгын фасад эвдэрсэн, өнгөлгөөний шавар нимгэн хийгдсэн.

Зураг 2. Захиалагчийн хяналт бүрэн хэрэгжүүлээгүй, чанартай гүйцэтгэгдээгүй ТАХ



Тайлбар: ХУД, “Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга” (10 дугаар хороо)



Тайлбар: СХД, “Ногоон байгууламж бүхий хүүхдийн тоглоомын талбайн тохижилт” (4-р хороо)



БГД, “Бага сургууль цэцэрлэгийн гадна тохижилтын ажил”



НД, “Усны машин худалдан авах ажил”



ЧД, “Алслагдсан хороодод үйлчлэх автобус”

Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд ТАХ-г чанартай гүйцэтгээгүйгээс илэрсэн зөрчил, тухайлбал:

- ЧД, “Хорооны цогцолбор барилга” (24 дүгээр хороо), гүйцэтгэгч Гегатера ХХК, гэрээний дүн 2,933.8 төгрөг, улсын комисс ажиллаагүй байхад нүүж орсон, заслын ажил буюу хаалганы амлагаа, хана зарим хэсэгт цуурсан, зоорины давхрын узелийн өрөөний шал хагарч цуурсан;
- ЧД, “Хорооны цогцолбор барилга” (17 дугаар хороо), гүйцэтгэгч Рокгранд ХХК, гэрээний дүн 2,480.0 сая төгрөг, 2 давхрын 00 өрөөний дүүжин тааз нурсан;
- СХД, “Байрны фасад засвар” (20 дугаар хороо) төсөвт өртөг 1,323.3 сая төгрөг, (2 багцад задарсан) Багц 1- гүйцэтгэгч Хэрмээдэй ХХК, гэрээний дүн 276.4 сая төгрөг, фасадын булан цөмөрч, цуурч хагарсан, балконы будаг хуурсан, Багц 2- Төрөлх мөрөн ХХК, гэрээний дүн 404.5 сая төгрөг, тус 2 ажлын 73-р байрны фасад хуурсан, 2-р байрны балконы будаг хуурсан;
- БНД, “Хоёрдугаар хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил”, гүйцэтгэгч Өндөр говь мэргэн интернэшнл ХХК, гэрээний дүн 1,209.5 сая төгрөг, явган замын ажил дутуу хийгдсэн;
- НД, “Илч хотхоноос Наадмын хэсгийн шинэ зам хүртэлх авто замын ажил”, гүйцэтгэгч Велдедлайна монголиа ХХК, гэрээний дүн 1,088.1 сая төгрөг, явган замын чигжээс дутуу, хөтөч хавтангууд эвдэрсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөтөч хавтангийн эхлэл төгсгөл байхгүй, стандартын дагуу хийж гүйцэтгээгүй, авто замын бродюр бутарч эвдэрсэн, замын тэмдэглэгээ хуурч бүдгэрсэн;
- БГД, “Эмүжин сүрьеэгийн эмнэлгийн их засварын ажил” гүйцэтгэгч Жигүүрт хөсөг ХХК, гэрээний дүн 908.9 сая төгрөг, хаалганы амлагааг чанаргүй хийсэн, сантехникийн тоноглол эвдэрсэн;
- БНД, “Байдлаг хэсгийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил” гүйцэтгэгч ИГ ХХК, гэрээний дүн 759.2 сая төгрөг, 2025 онд гэрээнд заасан ажлыг гүйцэтгээгүй;
- СХД, “Автобусны буудал шинээр байгуулах” (6 байршилд), гүйцэтгэгч Мега констракшн ХХК, гэрээний дүн 629.2 сая төгрөг, 3 байршилд хийгдсэн автобусны буудлын хаалга эвдэрсэн, мэдээллийн самбарын залгуур эвдэрсэн, суурийн бетон цутгалгүй шороон дээр байршуулсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шатыг стандартын дагуу гүйцэтгээгүй;
- БЗД, “Гачуурт эрүүл мэндийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил”, гүйцэтгэгч Био риажент ХХК, гэрээний дүн 188.0 сая төгрөг, эмнэлгийн зориулалттай автомашины тусгай тоноглолыг бүрэн хийгээгүй;
- СХД, “27 дугаар байрны урд талд байрлах хөл бөмбөгийн талбайн засварын ажил” 16 дугаар хороо, гүйцэтгэгч Ньюпрестиж констракшн ХХК, гэрээний дүн 186.8 сая төгрөг, хиймэл зүлэг халцарсан, хашаа эвдэрсэн, чанартай гүйцэтгээгүй;



- СХД, “Тоглоомын талбайн засвар, шинэчлэлтийн ажил” (20 дугаар хороо), гүйцэтгэгч Шүрэн гоёл ХХК, гэрээний дүн 134.5 сая төгрөг, бетон талбай хагарч, будаг хуурсан;
- СБД, 9-р хороонд тохижилт, гүйцэтгэгч Премиум эко ХХК, гэрээний дүн 135.9 сая төгрөг, турникийн суурийн боолт, хамгаалалтын пивер таггүй, тоглоомын талбайн бетон хагарсан, пүрш суурьтай дүүжин тоглоомын суурийг бэхлээгүй;
- НД, “Замын тэмдэг тэмдэглэгээ сэргээх ажил”, гүйцэтгэгч Би Эс Эм Жи ХХК, гэрээний дүн 128.6 сая төгрөг, замын тэмдэг тэмдэглэгээ бүдгэрч арилсан;
- ЧД, “40 мянгат 23 дугаар байрны дээвэр засварын ажил” (2 дугаар хороо), гүйцэтгэгч Интел Хайтек ХХК, гэрээний дүн 105.4 сая төгрөг, борооны усны хаялга эвдэрч, цуурсан;
- ЧД, “Дүүргийн 17-р сургуулийн спорт заалны засвар”, гүйцэтгэгч Эко энержи ресурс ХХК, гэрээний дүн 74.8 сая төгрөг, заалны таазны замаск хуурсан;
- СБД, “3-р хороо, 2а байрны баруун талд ногоон байгууламж тохижилтын ажил”, гүйцэтгэгч Их баян буурал ХХК, гэрээний дүн 38.5 сая төгрөг, цэцгийн мандлын 2 сандал эвдэрсэн.

Зураг 3. Чанартай гүйцэтгээгүй ТАХ




ЧД, “Дүүргийн 17-р сургуулийн спорт заалны засвар”



ЧД, Хорооны цогцолбор барилга (17 дугаар хороо)



БНД, 2-р хорооны цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажил



СБД, 10-р хороо, 13,15,30,30б, 36-р байрны гадна авто зогсоол, явган зам талбайн тохижилтын ажил



СХД, Байрны фасад засварын ажил, (20 дугаар хороо)



НД, Замын тэмдэг тэмдэглэгээ сэргээх ажил

3.6. Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Барилгын тухай хуулийн 3.6-д “Захиалагч..., зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл зөрчил, дутагдал илэрсэн тохиолдолд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцож ажиллана” Иргэний тухай хуулийн 350.1.1-д “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.7. МУ-ын ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралт “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.1²⁷, 2.3²⁸-т заасны дагуу үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулах, мөн ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын

²⁷ 2.1.Захиалагчийн үйл ажиллагаа нь Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан зарчмыг хэрэгжүүлж, шаардлагыг хангуулахад чиглэгдэх бөгөөд барилга байгууламж барих нөхцөлийг бүрдүүлэх, оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, хяналт тавих замаар хэрэгжинэ.

²⁸ 2.3.Энэхүү дүрмийн 2.2-т заасны дагуу чиг үүргээ өөр этгээдэд шилжүүлэх тохиолдолд холбогдох баримт бичгийг барилга байгууламжийн баримт бичигт хавсаргана. Захиалагчийн чиг үүргийг бусдад шилжүүлсэн нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй



4.4.1²⁹-д заасан захиалагчийн хяналт хэрэгжүүлэх холбогдох зөвшөөрлийг авсан байгууллагууд хяналт хэрэгжүүлэхээр заасан.

3.8. Тайлант онд хэрэгжсэн ТАХ-нд “Барилга хөгжлийн төв” ТӨХК, “НЗХГ”, “НХОГ”, “ГУББГ”, “УБ” лифт ОНӨААТҮГ-ууд барилга байгууламж, авто зам, дэд бүтцийн ажилд холбогдох чиг үүргийн дагуу дүүргүүдтэй гэрээ байгуулж хяналт хэрэгжүүлэн ажилласан байна.

3.9. Харин барилга байгууламж, авто зам дэд бүтэц, их засварын ажлуудад дүүргүүдийн захиалагчийн алба, хэлтсээс дараах хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 8. Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд

№	Дүүргийн нэр	ТАХ-ний тоо	Захиалагчийн хяналтын зардал	Захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллага
1	БГД	38	254.1	Баянгол дүүргийн захиалагчийн алба ОНӨААТҮГ
			62.4	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
			12.0	Улаанбаатар лифт ОНӨААТҮГ
2	БЗД	42	180.9	Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төв ОНӨААТҮГ
			30.3	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
			114.0	Нийслэлийн замын хөгжлийн газар
3	БНД	-	-	-
4	БХД	1	0.6	БХД-ийн Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
5	НД	-	-	-
6	СБД	115	517.1	СБД-ийн Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
			229.8	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
7	СХД	34	124.3	Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ
			145.3	Хан-уул дүүргийн Яармаг ОНӨААТҮГ
8	ХУД	42	194.2	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
			45.2	Нийслэлийн замын хөгжлийн газар
			14.8	ХУД-ийн ЗДТГ-ын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн албан хаагчид
			124.0	Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ
9	ЧД	30	47.8	Барилгын хөгжлийн төв ТӨХК
			134.7	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ
			11.6	Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ
Нийт		302	2,243.1	

3.10. “БГД, БЗД, СХД, ХУД, ЧД”-үүдийн ОНӨААТҮГ-аас ТАХ-ний гүйцэтгэлийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж тайлагнаж байгаа боловч ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын дагуу хэрэгжүүлээгүй, тайлагнаж хэвшээгүй байна.

3.11. Дараах дүүргүүд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, тоног төхөөрөмж, зураг төсвийн ажил хүлээн авахдаа мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллагуудтай гэрээ байгуулаагүй, ажлын хэсгээр хяналт хэрэгжүүлж, захиалагчийн хяналтын зардлыг авсан нь дээрх хууль, журамтай нийцээгүй байна.

- СБД-ийн “Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс” ТАХ, 517.1 сая төгрөг;
- ХУД-ийн “Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс” ТАХ, 14.8 сая төгрөг;
- БХД-ийн “Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс” ТАХ, 0.6 сая төгрөг.

3.12. Аудитын явцад стандартын шаардлага хангаагүй дараах ТАХ-г засуулж, залруулсан.

- БЗД-ийн “Асфальт бетоны үйлдвэрийн ажилчдын байр, хашаа, харуулын байр, агуулахын байрны барилгын ажил” Багц-1 гүйцэтгэгч Моринсувд констракшн ХХК, харуулын байр барих ажлыг бүрэн гүйцэтгүүлсэн;
- ХУД-ийн “Цэцэрлэгт хүрээлэн, спорт талбай, зам талбайн тохижилтын ажил”, II дугаар үе шат (21 дүгээр хороо), гүйцэтгэгч Гарденсити ХХК, хүүхдийн савлуурын труба хаалтыг суурилуулсан;
- БГД, “Явган шат, явган хүний зам засварын ажил”, гүйцэтгэгч Антек ХХК, дутуу ажлуудыг бүрэн гүйцэтгүүлсэн.

²⁹ 4.4.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу техник, технологийн захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвшөөрлийг авсан байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:



Зураг 4. Аудитын явцад бүрэн гүйцэтгүүлсэн ажлууд



Тайлбар: БЗД, УБЗЗАГ-ын харуулын байр Тайлбар: ХУД, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт

Шийдвэрлэлт: Захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, үе шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, холбогдох дүрэм журмыг мөрдөөгүй, чанартай гүйцэтгээгүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.



БҮЛЭГ 4. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН 57.6 ХУВЬД САНХҮҮЖИЛТ ОЛГОЖ, ХЭРЭГЖИЖ ДУУССАН ТАХ-НИЙ ҮР ДҮНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙН 16.0 ХУВИЙГ ӨМЧИЙН БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.

4.1. Тайлант онд дүүргүүдийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 792 ТАХ-нд 397,483.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 544 ТАХ-нд 229,181.0 сая төгрөг буюу 57.6 хувийн санхүүжилт олгосон.

Хүснэгт 9. ДТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-нд олгосон санхүүжилт

(сая.төг)

№	Дүүрэг	Өмнөх оноос хэрэгжсэн				2025 онд шинээр хэрэгжсэн				Нийт			
		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн		Санхүүжих		Санхүүжсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	32	19,098.8	31	12,890.7	32	26,629.6	28	18,325.2	64	45,728.4	59	31,215.9
2	БЗД	51	36,610.8	38	20,827.2	27	14,602.7	24	11,409.8	78	51,213.5	62	32,237.0
3	БНД	26	3,819.1	16	2,453.2	28	4,450.0	4	1,164.0	54	8,269.1	20	3,617.2
4	БХД	4	437.3	4	407.6	13	820.2	12	691.9	17	1,257.5	16	1,099.5
5	НД	2	319.8	2	303.5	19	1,010.0	15	778.6	21	1,329.8	17	1,082.1
6	СБД	88	72,783.0	72	36,633.6	49	45,914.3	58	30,376.9	137	118,697.3	130	67,010.5
7	СХД	25	11,032.7	23	4,928.1	65	32,379.4	35	25,765.1	90	43,412.1	58	30,693.2
8	ХУД	88	48,725.8	61	25,982.5	30	17,609.8	29	9,605.9	118	66,335.6	90	35,588.4
9	ЧД	42	18,207.3	26	10,002.6	171	43,032.4	66	16,634.6	213	61,239.7	92	26,637.2
	Нийт	358	211,034.7	273	114,429.0	434	186,448.4	271	114,752.0	792	397,483.0	544	229,181.0

4.2. Өмнөх оноос шилжин хэрэгжиж буй 358 ТАХ-нд 211,034.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос гүйцэтгэлээр 114,429.0 (54.2%) сая төгрөг, шинээр хэрэгжих 434 ТАХ-нд 186,448.4 сая төгрөгийг олгохоос 114,752.0 (61.5%) сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.

4.3. Нийт олгосон санхүүжилтээс 2,894.1(1.2%) сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардалд олгосон байна.

4.4. Хэрэгжиж дуусаагүй ТАХ-ний үлдэгдэл, хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаа хөрөнгө 8,937.8 сая төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

Хүснэгт 10. 2025 онд хэрэгжсэн ТАХ-нд олгосон санхүүжилт барьцаа, алданги

(сая.төг)

№	Дүүрэг	Батлагдсан төсөвт өртөг		Олгогдсон санхүүжилт		Барьцаанд		Алданги	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	64	57,038.3	59	31,215.9	44	1,188.1	9	6.2
2	БЗД	78	96,591.8	62	32,237.0	35	2,194.9	2	3.0
3	БНД	54	9,437.7	20	3,617.2	11	124.5	-	-
4	БХД	17	1,257.6	16	1,099.5	12	41.9	2	6.2
5	НД	21	2,280.0	17	1,082.1	13	260.7	-	-
6	СБД	137	165,980.6	130	67,010.5	111	1,973.3	2	24.6
7	СХД	90	57,045.3	58	30,693.2	17	539.7	8	14.1
8	ХУД	118	150,132.8	90	35,588.4	40	1,107.1	19	7.8
9	ЧД	213	79,819.2	92	26,637.2	40	967.6	3	2.9
	Нийт	792	619,583.3	568	229,181.0	323	8,397.8	45	64.8

4.5. Захиалагч байгууллагуудаас гэрээний үүргээ зөрчсөн 45 гүйцэтгэгчид 64.8 сая төгрөгийн алдангийг тооцсон байна.

4.6. Зарим ТАХ-нд олгосон санхүүжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

Гүйцэтгэлд үндэслээгүй, зориулалт бусаар олгосон санхүүжилт:

- ЧД, “40 мянгат 26 дугаар байрны дээвэр засварын ажил” (2 дугаар хороо), гүйцэтгэгч Цац Орхон ХХК, гэрээний дүн 107.0 төгрөг, ус зайлуулах хэвтээ хоолой Ф-150, босоо хоолой Ф-100 хоолой хийгдээгүй байхад тус ажлын санхүүжилтэд 8.9 сая төгрөг олгосон;
- БГД, “Гарааш буулгасан талбайд тохижилт бүтээн байгуулалтын ажил”, гүйцэтгэгч Нано-экологи ХХК, гэрээний дүн 1,830.0 сая төгрөг, 15-р хорооны зүлэгжүүлэлтийн ажил хийгдээгүй байхад тус ажлын санхүүжилтэд 16.3 сая төгрөг олгосон;
- СХД, “Иргэний танхимд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл” (3 дугаар хороо), гүйцэтгэгч Прогресс интермедишн ХХК, гэрээний дүн 48.3 сая төгрөг, нийлүүлэгдэх индэрийг хүлээн аваагүй байхад тус ажлын санхүүжилтэд 1.5 сая төгрөг олгосон.

Зураг төсөв, зохиогчийн болон техник хяналтын зардалтай холбоотой:



- ХУД, Зураг төсөв техникийн хяналтын зардалд 14.7 сая төгрөгийг авч, албан хаагчдын дансанд шилжүүлсэн;

Гэрээний хугацаа дууссан байхад магадлашгүй ажлын санхүүжилт олгосон:

- ХУД, “Иргэдэд үйлчлэх төв байрны орчим болон чингисийн өргөн чөлөөнөөс үйлдвэрийн цагаан хаалга хүртэл авто замын засвар шинэчлэлтийн ажил” (20 дугаар хороо), гүйцэтгэгч Сантбаян бэрх ХХК, гэрээний дүн 833.4 сая төгрөг, ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссаны дараа худгийн төмөр бетон таг тавих, асфальтын ажлыг гэрээ сунган хийлгэж 10.8 сая төгрөг олгосон.

4.7. Хэрэгжиж дууссан 144,969.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 326 ТАХ-г ашиглагч байгууллагууд хөрөнгийн бүртгэлд, 57,700.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 122 ТАХ-г зардалд тус тус бүртгэж, 24,346.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 86 ТАХ-г хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

Хүснэгт 11. Хөрөнгийг бүртгэлд тусгасан байдал

(сая. төг)

№	Дүүргийн нэр	Хэрэгжиж дууссан ТАХ		Бүртгэсэн ТАХ		Зардалд тусгасан		Бүртгээгүй ТАХ	
		Тоо	Гэрээний дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БГД	47	26,372.3	40	21,391.0	-	-	7	4,981.3
2	БЗД	39	45,896.5	31	38,262.4	7	7,484.2	1	149.9
3	БНД	26	4,135.9	22	3,895.7	4	240.2	-	-
4	БХД	14	989.2	14	989.2	-	-	-	-
5	НД	14	2,033.3	10	1,687.4	1	156.5	2	189.4
6	СБД	151	57,285.7	103	33,423.2	5	10,230.5	43	13,631.9
7	СХД	84	34,826.3	41	7,893.8	30	24,720.4	13	2,212.1
8	ХУД	73	34,024.1	40	21,447.7	13	9395.0	20	3,181.4
9	ЧД	87	21,452.9	25	15,979.4	62	5,473.5	-	-
Нийт		535	227,016.1	326	144,969.8	122	57,700.3	86	24,346.0

4.8. Өмчийн бүртгэлд тусгах боломжгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай дараах ТАХ-г зардалд тусгасан байна. Тухайлбал:

- Авто зогсоол, цахилгаан хангамж, хүчдэл сайжруулах 11,785.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 17 ТАХ;
- Газар чөлөөлөх 29,125.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 ТАХ;
- Нийтийн зориулалттай орон сууцны дээвэр болон фасад засвар 10,079.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй 40 ТАХ;
- Зураг төсөв боловсруулах 2,687.63 сая төгрөгийн гэрээний дүнтэй 50 ТАХ;
- Тоног төхөөрөмж 625.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ТАХ;
- Тохижилт, замын тэмдэг, тэмдэглэгээ сэргээх 3,368.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 4 ТАХ.

4.9. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-г хүлээн авч хөрөнгө бүртгэлд тусгасан ч зарим хөрөнгийн ашиглалт нь хангалтгүй байна. Тухайлбал:

- БЗД, “Хаягдал цаас хуримтлуулах, дахин боловсруулахад бэлтгэх цэгийн барилгын болон тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил”, гүйцэтгэгч Смарт тракс ХХК, гэрээний дүн 799.5 сая төгрөг, бэлтгэл бүрэн хангагдаагүй, хүний нөөц, технологийн боловсруулалт зэргээс шалтгаалж хөрөнгийг ашиглалтгүй;
- СБД “16,281,248 дугаар цэцэрлэгийн шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад хангамжийн материал ажил” Багц-2, гүйцэтгэгч Санаа мед трейд ХХК, гэрээний дүн 564.8 төгрөг, 16-р цэцэрлэгийн барилга дуусаагүй байхад 267.5 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бэлтгэж, хөрөнгийг ашиглаагүй, нийлүүлэгчийн агуулахад хадгалагдаж байна;
- НД, “Ус дулаан дамжуулах төв №10 өргөтгөлийн тоног төхөөрөмж худалдан авах”, гүйцэтгэгч Перпект солюшн энд инженеринг ХХК, гэрээний дүн 556.3 сая төгрөг, нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжөөс 2000л багтаамжтай тэлэлтийн сав, халаалтын насос зэргийг ашиглаагүй;
- ЧД, “Дүүргийн татварын хэлтэст шаардлагатай тавилга, эд хогшил худалдаж авах ажил”, Гүйцэтгэгч Микросити ХХК, гэрээний дүн 340.0 сая төгрөг, нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс ухаалаг индэр, таазны спикер, ширээний микрофон, проектор, проекторын дэлгэц зэргийг ашиглаагүй;
- СБД, “6,35-р сургуулийн үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх” Багц-1, гүйцэтгэгч Чиглэл ХХК, гэрээний дүн 247.4 сая төгрөг, 6-р сургуульд нийлүүлсэн 119.1 сая төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг ашиглаагүй, хадгалсан;
- ЧД, 117, 57-р сургуульд шаардлагатай гал тогооны төхөөрөмж, гүйцэтгэгч Чиглэл ХХК, гэрээний дүн 101.1 сая төгрөг, 117-р сургуульд нийлүүлэгдсэн 44.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг, 57-р сургуульд нийлүүлсэн 2.7 сая төгрөгийн 2 хөлдөөгчийг тус тус ашиглаагүй;



- НД, “2 дугаар хорооны төрийн байгууллагуудын нэгдсэн халаалтын системийн өргөтгөлийн тоног төхөөрөмж худалдан авах”, гүйцэтгэгч Хот төлөвлөлтийн хүрээлэн ХХК, гэрээний дүн 47.5 сая төгрөг, худалдан авсан зуухыг суурилуулаагүйгээс ашиглалтгүй;
- СБД, “6,35,159 дүгээр сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тоног төхөөрөмж” Багц-7, гүйцэтгэгч Чиглэл ХХК, гэрээний дүн 42.4 сая төгрөг, 6-р сургуульд нийлүүлэгдсэн 21.8 төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглаагүй, хурааж хадгалсан;
- ЧД, “Чингэлтэй цогцолборт шаардлагатай гал тогооны төхөөрөмж” гүйцэтгэгч Чиглэл ХХК, гэрээний дүн 25.3 сая төгрөг, хэншүү сорогчийг угсраагүйгээс ашиглалтгүй;
- БХД, “Биеийн тамир спорт хороонд спортын хэрэгсэл нийлүүлэх”, гүйцэтгэгч Голденбэмби ХХК, гэрээний дүн 19.0 сая төгрөг, 2-р хорооны заал ашиглалтад ороогүй байгаагаас сагс, волейболын бөмбөг, тор, онооны самбар зэргийг ашиглаагүй.

Зураг 5. Ашиглалтгүй байгаа тоног төхөөрөмжүүд



Тайлбар: СБД, 16-р цэцэрлэг



Тайлбар: СБД, 6-р сургууль



Тайлбар: ЧД, 117-р сургууль



Тайлбар: БНД, халаалтын зуух

Шийдвэрлэлт: Хөрөнгө оруулалтын шинж чанартай ТАХ-г оновчтой төлөвлөөгүй, хэрэгцээ шаардлагад нийцсэн техник тоног төхөөрөмж бэлтгээгүй, хөрөнгө бүртгэлд тусгаагүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулаагүй зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулахдаа Төсвийн тухай хуульд заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгон ажиллаагүй байна.
2. Дүүргүүдийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 434 төсөл, арга хэмжээ (багцад задарсан 519) нь хөгжлийн бодлогын дунд хугацааны баримт бичигт бүрэн нийцээгүй, нийт төсөл, арга хэмжээний 49.0 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байхад баталсан нь Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.
3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төсөвт тусган баталсан нь хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх зэргээр төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.
4. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийг бүрэн мөрдөөгүй, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад ил тод, нээлттэй өрсөлдөх боломжийг бүрэн хангаагүй, зарим төсөл арга хэмжээнд шаардлагад нийцсэн гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.
5. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих мэргэжлийн байгууллага, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын зарим ажлууд чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь үр ашигт нөлөөлж байна.
6. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгө ашиглалтгүй, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл арга хэмжээг хэрэгжүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.
7. Хэрэгжиж дууссан ТАХ-ний үр дүнд бий болсон хөрөнгийн 16.0 хувийг өмчийн бүртгэлд тусгаагүй байна.



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Дүүргүүдийн ИТХ, ЗД нарт:

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулахдаа Төсвийн тухай хуульд заасан иж бүрэн, үнэн зөв, хариуцлагатай, ил тод байдлыг хангасан байх, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг мөрдөж ажиллах.
2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэл, санхүүжилтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, заавар, аргачлалыг чанд мөрдөж ажиллах.

Дүүргүүдийн ЗДТГ болон Худалдан авах ажиллагааны албаны дарга нарт:

1. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр тооцоолсон, зураг төсөвгүй, ажлын даалгавар, техникийн нөхцөлгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй, төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх.
2. худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн хууль болон бусад хууль тогтоомжоор заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулах.
3. Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн шатанд зөрчил арилахгүй, жил бүр давтагдан гарч буйг зогсоох, хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт болон захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, үр дүнг тооцож ажиллах.
5. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний дүнд бий болсон хөрөнгийг өмчийн бүртгэлд бүрэн тусгах.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Замцдын гудамж 3, 27 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16052
Утас: (976-11) 38 16 18
Цахим шуудан: info@bgd.mn
Цахим хуудас: www.bgd.mn

2026.05.13 № 01/1451
танай _____ -ны № _____ -т
Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

"Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2026/05-11-ШТА-НА/ тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүгнэлттэй холбоотой санал, нотлох баримтыг хавсралтаар хүргүүлэв.

Цаашид аудитын шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг давтахгүй, өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.

Хавсралт 29 хуудастай.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Энхтайваны өргөн чөлөө-57, 13 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13330
Утас/Факс: (976-51) 26 63 59
Цахим хуудас: www.bzd.ub.gov.mn

2026.05.14 № 02/1360
танай _____ 2026.05.04 -ны № 1046 _____ -т
Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Баянзүрх дүүрэгт хэрэгжүүлсэн "Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын (НТАГ-2026/05-11-ШТА-НА) тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.

Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
Дэлгэц Бат-Олзий
2026.05.14 15:57



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1011
Цахим хуудас: www.bagakhangai.ub.gov.mn

2026.05.14 № 04/322
танай _____ 2026.05.04 -ны № 1046 _____ -т
Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

"Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд" сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2026/05-11-ШТА-НА/ тайлангийн төсөлд саналгүй болно.

Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар
Удирдлага
Тамгын дарга
Лхагваа Санжийжамц
2026.05.14 18:09



НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.Дэлгэцэвийн гудамж, 2 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот, 12790
Утас: (976) 7023 2252, 7023 2204
Цахим шуудан: nalaibgd.gov@webmail.com
Цахим хуудас: www.naii.ub.gov.mn

2026.05.14 № 00/939
танай _____ -ны № _____ -т

Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхааран ажиллаж байна.

Д.НАМБАЯР

Alban bichig 2026\AlbanA6.docx

1226040070

1226120041



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ




СУХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Дөнөрийн гудамж 13, 11 дүгээр хороолол,
7 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14190, Утас: (976) 7007 0109
Цахим хуудас: info@sbd.gov.mn
Цахим хуудас: www.sbd.ub.gov.mn

2026.05.14 № 04/1409
танай -ны № -т

Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд болон үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцав. Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.



Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх
Элчийншүр Энхбаяр
2026.05.14 17:41




СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

Нутгийн захиргааны нэгдсэн байр,
Баянголын гудамж 1, 27 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар хот, 18082
Утас: (976) 7017 2216
Цахим хуудас: www.shd.mn

2026.05.13 № 01/1891
танай 2026.05.04 -ны № 1046 -т

Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд аудитын тайлангийн төсөлд өгөх саналаа 10 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ" гэж заасныг үндэслэн манай байгууллага нь "Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын /НТАГ-2026/05-11- ШТА-НА/ тайланд хүргүүлэх "Саналгүй" болно.



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар
Удирдлага
Засаг дарга
Цэдэвчидэмбэ Баттөр
2026.05.13 13:28

1826050005



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж 10, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7777 1992
Цахим хуудас: info@chingeltei.gov.mn
Цахим хуудас: www.chingeltei.gov.mn

2026.05.13 № 03/1251
танай -ны № -т

Г НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

"Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийн саналыг хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.



1526110076



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Иргэдэд үйлчлэх төв байр,
Чингэлтэй өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 10462
Утас: (976-11) 7777 1966
Цахим хуудас: info@hanuul.gov.mn
Цахим хуудас: www.hanuul.mn

2026.05.12 № 04/887
танай -ны № -т

Г Хариу хүргүүлэх тухай

Дүүргийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан.

Аудитаар илэрсэн зөрчлүүдэд дараах тайлбарыг хавсралтуудаар хүргүүлж байна.

- Гэрээний хугацаа дууссан байхад магадлашгүй ажлын санхүүжилт олгоосон: ХУД. "Иргэдэд үйлчлэх төв байрны орчим болон чингэлтэй өргөн чөлөөнөөс үйлдвэрийн цагаан хаалга хүртэл авто замын засвар шинэчлэлтийн ажил" (20 дугаар хороо), гүйцэтгэгч Сантбаян бэрх ХХК, гэрээний дүн 833.4 сая төгрөг, ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссаны дараа худгийн төмөр бетон тэг тавих, асфальтын ахлаг гэрээ сунган хийлгэж 10.8 сая төгрөг олгоосон тухай тайлбар /Хавсралт 1-т/
 - Зураг төсөв, зохиогчийн болон техник хяналтын зардалтай холбоотой: ХУД. Зураг төсөв техникийн хяналтын зардалд 14.7 сая төгрөгийг авч, албан хаагчдын дансанд шилжүүлсэн тухай тайлбар /Хавсралт 2-т/
 - ХУД. "Өрхийн эрүүл мэндийн төвийн байр худалдан авах" (24 дүгээр хороо), нийлүүлэгч иргэн Л.О. гэрээний дүн 965.0 сая төгрөг, ажлын даалгавар боловсруулаагүй, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх стандарт хангаагүй тухай тайлбар /Хавсралт 3-т/
- 1 дүгээр хавсралт: Хавсралт 1, 11 хуудастай.
2 дугаар хавсралт: Хавсралт 2, 37 хуудастай.
3 дугаар хавсралт: Хавсралт 3, 7 хуудастай.



17261300101



САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аудитын тайлангийн төсөлтэй дүүргүүд танилцаж, Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд БЗД, БХД, НД, СБД, СХД-үүдээс саналгүй, цаашид аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн.

Төрийн аудитын тухай хуулийн 18.2-д заасан хуулийн хугацаанд БНД-ээс санал ирүүлээгүй.

БГД, ХУД, ЧД-ийн ЗДТГ-уудаас 12 санал ирүүлснээс, хүлээн авах боломжтой саналыг авч бусад саналыг хэвээр үлдээв.

№	Ирүүлсэн санал	Саналыг хүлээн авсан эсэх	НТАГ-ын тайлбар
БГД-ийн ЗДТГ-аас 2026 оны 05 дугаар сарын 13-ны 01/1451 дугаар албан бичиг			
1	“Гарааш буулгасан талбайд тохижилт бүтээн байгуулалтын ажил” ...15-р хорооны зүлэгжүүлэлтийн ажил хийгдээгүй ажил хийгдээгүй байхад тус ажлын санхүүжилтэд 16.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон гэж дүгнэсэнтэй санал нийлэхгүй гэж ирүүлсэн. Хариу тайлбарт: Баянгол дүүргийн захиалагчийн хяналтыг алба ОНӨААТҮГ хэрэгжүүлж, ТАХ-г бүрэн дуусгасан тухай захиалагчийн хяналтын тайлан, гэрээ дүгнэсэн маягыг үндэслэж санхүүжилт олгосон. Комисс хүлээн авахад хүйтний улирал байсан тул зүлэгжүүлэх ажлыг дулааны улиралд хийх гүйцэтгэгчийн удаа дараа гаргасан хүсэлтийн дагуу 2026.05.10-2026.05.30-ны өдрүүдэд зүлэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх саналтай.	Үгүй	Саналтай танилцаж, гүйцэтгээгүй ажлыг бүрэн гүйцэтгүүлж, нотлох баримтыг ирүүлэх, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.
2	“Боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах” багц 02 бараа нийлүүлэх ажил, тоног төхөөрөмж худалдан авах зардлаас сургалтын зардалд 50.0 сая төгрөгийн зориулалт бусаар зарцуулсанд төлбөрийн акт тогтоох аудитын шийдвэртэй санал нийлэхгүй гэж ирүүлсэн. Хариу тайлбарт: БГДХААА/ОН-25-08-02 гэрээтэй “Боловсролын байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах(багц2) ажлын техникийн тодорхойлолтод “25 СӨБ байгууллагын багш нарыг олон улсын хөтөлбөрт сургалтад танхимаар хамруулж, хэрэглэгдэхүүн ашиглах ном гарын авлагаар хангах, сургалт явуулах”, барааны үнийн задаргаанд “Багшийн сургалт, туршлага судлах зардал” гэж заасныг үндэслэн санхүүжилт олгосон. Тус сургалтын хүрээнд гэрээний үнийн дүнгээс давсан, эдийн засгийн хүндрэлтэй, багш боловсон хүчнээс хувь зардал гарсан тул төлбөрийн чадваргүй нөхцөл үүссэн.	Үгүй	Саналтай танилцахад хөрөнгө оруулалтын ТАХ-ний техникийн тодорхойлолт боловсруулахдаа “урсгал зардал”-ыг санхүүжүүлэхээр тусгасан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй ажиллах албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.
